

ЭРЧИМ ХҮЧ ҮЙЛДВЭРЛЭХ, ТҮГЭЭХ, ХАНГАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВАХ, СУНГУУЛАХ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХАД БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

Хуулийн этгээд тусгай зөвшөөрөл авах, сунгуулах, нэмэлт өөрчлөлт оруулах тухай өргөдлийг холбогдох бичиг баримтын хамт бүрдүүлж ЭХЗЗ-д гаргана.

1. Тусгай зөвшөөрөл авах:

1.1. Тусгай зөвшөөрөл авах тухай өргөдлөө эрхлэх үйл ажиллагааны төрөлтэй уялдуулан дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна.

- ❖ “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”-ийн 11 дүгээр зүйлд заасан бичиг баримт.
- ❖ “Эрчим хүчний тухай хууль”-ийн 21 дүгээр зүйлийн 21.2-д заасан бичиг баримт,
 1. Техник, эдийн засгийн үндэслэл
 2. Эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах эрчим хүчний нөөцийн судалгаа
 3. Үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах эрчим хүчний төрөл, хэмжээ чанарын үзүүлэлт
 4. Үйлд ажиллагаандаа ашиглах тоног төхөөрөмжийн үндсэн үзүүлэлт
 5. Үйлчлэх хүрээ эзэмшлийн зааг, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамж, хэрэглээний тэнцэл
 6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
 7. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
 8. Тухайн хуулийн этгээдийн санхүү, хөрөнгийн нөөц, эдийн засгийн чадавхи
 9. Үйл ажиллагаагаа эхлэх хугацаа, хөрөнгө оруулалтын хэмжээ, санхүүжүүлэх эх үүсвэр
 10. Мэргэжлийн боловсон хүчин, тэдгээрийн дадлага, туршлага.

2. Тусгай зөвшөөрөл сунгуулах:

2.1. Тусгай зөвшөөрөл сунгуулах тухай өргөдөл

2.2. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зохих ёсоор биелүүлж ирсэн талаарх тайлан, техник технологийн хувьд цаашид үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжтой талаарх мэдээлэл

2.3. Тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах шинэчлэл

2.3.1. Тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэх тухай өргөдлөө эрхлэх үйл ажиллагааны төрөлтэй уялдуулан дээр дурьдсан бичиг баримтыг ирүүлэх

2.4. Тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгжийн захирал /дарга/ бичиг баримтын үнэн зөв болохыг гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулсан байна.

Увс аймгийн ЭХЗЗ-өөс тусгай зөвшөөрөл эзэмшигч

аж ахуйн нэгжүүд

№	ААНБ-н нэр	Олгосон огноо	Хүчинтэй хугацаа
1	Увс аймгийн дулааны II-р станц, ДШС ОНӨААТҮГ	2015.07.01	2020.07.01
2	Увс дулааны станц ХХК	2014.01.17	2019.01.17
3	ССТ-ОД ХХК	2014.12.10	2019.12.10
4	Дэвшил-Увс ХХК	2014.10.29	2019.10.29
5	Олон бригад ХХК	2014.01.03	2019.01.03
6	Насан-Илч ХХК	2015.04.21	2019.04.21
7	МХС ТӨК	2015.10.08	2016.10.08
8	Солонго Талст ХХК	2014.07.18	2019.07.18